



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/123

Бат-Өлзий сум

Гэрээ байгуулах тухай


Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ажлын хэсгийн 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 02 дугаар хуралдаанаар Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Хурдан морины уралдааны зам засах ажлыг “Ариунжим” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай шууд худалдан авах аргаар гэрээ байгуулсугай.

2. “Ариунжим” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулж, зам засварын ажилд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3. Хурдан морины уралдааны зам засах ажилд шаардагдах 18,000,000 (арван найман сая) төгрөгийг гэрээнд заасны дагуу Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Пүрэвсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН